



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар Д/69

Мөрөн сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан иргэн Ж.Энхбатын нэхэмжлэлтэй Мөрөн сумын Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хууль, эрх зүйн мэргэжилтэн (Г.Хишигбаатар)-ыг томилсугай.

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан бүхий л эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль, эрх зүйн мэргэжилтэн (Г.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР